



УРТЫН ДУУНД ХАНДАХ ХАНДЛАГЫН ХЭМЖҮҮРИЙН НЭГЭН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛЖ ТУРШСАН НЬ (МУБИС, Багшийн сургуулийн оюутнуудын жишээн дээр)

С.Батхуяг^а, Ч.Отгонбаяр^б, WENYA^в
^аМУБИС-Багшийн сургууль, доктор;
^бМУБИС-Багшийн сургууль, доктор;
^вБНХАУ, ӨМӨЗО

Холбоо барих зохиогч: otgonbayar.ch@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь монголчуудын биет бус соёлын өвийн үнэт бүтээл болох уртын дуунд бага ангийн болон хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын хандлагыг үнэлэх хэмжүүрийг боловсруулах, түүний хүчинтэй, найдвартай байдлыг баталгаажуулахад оршино. Судалгаанд МУБИС-ийн Багшийн сургуулийн бага ангийн болон хөгжмийн багш мэргэжлийн 1–4 дүгээр курсийн нийт 404 оюутан хамрагдав.

Судалгааны үр дүнд боловсруулсан хэмжүүрийн бүтэц, найдвартай байдал өндөр түвшинд байгааг тогтоолоо. Фактор шинжилгээгээр хуримтлагдсан тархалтын хувь 63.689%, КМО үзүүлэлт 0.948, статистикийн утга $p < 0.05$ гарсан нь хэмжүүрийн хүчинтэйг илтгэв. Найдвартай байдлыг илтгэх Кронбахын альфа коэффициент 0.952 байсан нь хэмжүүрийн дотоод нийцтэй байдал маш сайн болохыг харуулж байна. Шинжилгээгээр дөрвөн хүчин зүйл тодорсон. Үүнд: Фактор 1 – уртын дууг үнэт өв гэж үзэх, бахархах, эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой үзүүлэлтүүд; Фактор 2 – уртын дууг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй оролцох хандлага; Фактор 3 – уртын дууг хүрээлсэн нийгмийн орчин (гэр бүл, найз нөхөд, багш нар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл) болон өдөр тутмын дадал зуршил; Фактор 4 – хувь хүний мэдлэгийн түвшин, сонсох дуртай байдал.

Ийнхүү боловсруулсан хэмжүүр нь уртын дуунд хандах хандлагыг үнэлэх найдвартай хэрэгсэл болохын зэрэгцээ монголын биет бус соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, мөн хөгжмийн боловсролыг дэмжин хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Түлхүүр үг

Уртын дуу, биет бус соёлын өв, хандлагын хэмжүүр, хүчинтэй байдал, найдвартай байдал, хөгжмийн боловсрол

Удиртгал

Монголын ард түмний нүүдэлчин соёлд гүн шингэсэн соёлын биет бус өвийн нэг нь уртын дуу юм. “Уртын дуу” гэсэн нэршлийн талаар судлаачид дараах байдлаар тодорхойлж авч үзсэн байна. Тухайлбал: Монгол хэлний тайлбар толь бичигт (mongoltoli.mn) “Удаан аялгуулан дуулах ардын дуу, ардын айзам хэмнэл удаантай дуу” хэмээн тодорхойлсон бол БНМАУ-ын угсаатны зүй (1987) -номд “Монгол уртын дуу нь шүлэглэл, үгийн урттай холбоотой биш харин хөг аялгууны урт, цээлхэн” учир гэж үзсэн бол судлаач А.Алимаа (2013) “Монгол уртын дууны төрөл зүйл, тархалт, хувилбарын онцлог” бүтээлдээ “ая аялгуу, шүлэг яруу найргийн урт, дуулахуй байдал болоод агуулга, санаагаараа ч гүн гүнзгий” учраас уртын дуу гэсэн байна.

Монголын ардын уртын дуу бол монгол үндэстний буурал түүх, малчин ахуй, амьдралын гүнээс өөрөө урган гарч, монгол нутгийн байгалийн үзэсгэлэн, монгол хүний уужуу тайван сэтгэлийн зохилдлого, нүүдэлчдийн аж төрөхүй, зан заншлын өвөрмөц уянга болон төгөлдөржиж, цараа тавиун хөг аялгуу, төв эрхэмсэг намба, уран гоё нугалаа, баян чимэг бүхий шуранхай, хөг эгшгийн өвөрмөц онцлогтойн хувьд аливаа ард түмний дуунд үл давтагдах ховор шинж агуулсан ардын дууны урлагийн хосгүй уламжлалт сонгодог өв мөн юм (legalinfo.mn, 2004).

Уртын дуу нь уран яруу үг, уянгалаг сайхан аялгуу, соёлын гүн гүнзгий ач холбогдолтой гэдгээрээ онцлогтой. Монгол соёл иргэншлийн онцгой ололт, агуулга, хэлбэр, ая хөг, үг хэллэг, айзам хэм төгөлдрийн хувьд монгол соёлын өвөрмөц ололт болсон уртын дууны өв санг хадгалах, төрийн хамгаалалтад байлгах, дээдлэн дэлгэрүүлэх талаар 2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр 1.Монгол ардын уртын дууг залуу үед өвлүүлэн эзэмшүүлэх, дуулах эрдэмд сургаж, бүх нийтээр үндэсний бахархлын зэрэглэлээр дээдлэн дэлгэрүүлж, монгол үндэстэн, монгол хүний нэрийн хуудас, төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болгох өргөн олны хөдөлгөөн өрнүүлэхийг нийт ард иргэд, аймаг, нийслэлийн, төрийн болон төрийн бус байгууллага, соёл урлагийн ажилтан, зүтгэлтэн, эцэг эх, багш нарт уриалсугай 2.Уртын дууг сурвалжлан олох, сурган эзэмшүүлэх, судлан шинжлэх, сурталчлан даяаршуулах цогц асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг засгийн газарт чиглэл болгосугай (legalinfo.mn, 2004) хэмээн Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг буулгажээ. Мөн 2005 онд ЮНЕСКО «Монгол уртын дуу“- г Хүн төрөлхтний аман ба биет бус өвийн шилдэг дээж”-ээр тунхаглаж, 2008 онд “Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д бүртгэсэн (unesco.org, 2008). Н.Жанцанноров (2006) “Ер нь монгол уртын дууны судалгаа шинжилгээнд хандах бидний хандлагыг ихээхэн өргөжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Бид чухамдаа судалгаа нотолгоонд тулгуурласан дүгнэлт биш монгол уртын дууг хүн, байгаль, ёс заншилтай холбогдсон хуурай дүгнэлтэд тулгуурласан тайлбар дээр тушиж байснаа бүрэн орхих хэрэгтэй болж байна” хэмээн үзжээ. Ц. Чулуунцэцэг (2016) “Монгол Улс дахь уртын дуу, дуучдын тархалтын судалгаа” бүтээлдээ “...уртын дууны өв залгамжлал тасрах эрсдэлд орсон бүс нутгуудад уртын дууг сэргээн өвлүүлэх, сургалт семинарыг зохион байгуулж түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлага урган гарч

байна” хэмээн дүгнэсэн нь уртыг дууг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажил шаардлагатай байгааг илтгэж байна.

Халх ястны дунд уртын дууг дуулах арга барил, донж маяг шинж төрхөөр нь төв ба зүүн, баруун аймгийн аялгуу, Боржигин аялгуу, Баянбараатын аялгуу гэж ангилдаг. Халх уртын дууны эдгээр ангиллаас гадна Баяд, Дөрвөд, Захчин, Урианхай, Өөлд, Торгууд, Дарьганга, Барга, Үзэмчин зэрэг монголын олон ястан угсаатнууд дор бүрнээ өөр өөрийн өвөрмөц онцлог бүхий уртын дуутай. Уртын дуучин Д. Ширмэнтуйаа (2020) «Монгол уртын дуу маань уудам тэнэгэр нугалаатай, уран тансаг олон гоёл чимэглэлтэй, хүний сэтгэлийг бадруулан тайвшруулж байдаг үнэхээрийн сайхан урлал юм. Монгол уртын дуу нь монгол эх орны уудам тэнэгэр нутаг мөн өргөн сайхан голууд, өндөр өндөр шовх оргилууд, өтгөн ой модыг харуулан дуулж байдаг. Манай олон сайхан судлаачид уртын дууны өв соёлыг судалсаар ирсэн билээ. Уртын дуу нь өөрөө тайвшрал бясалгалын үүдтэй” хэмээжээ. Монгол ардын уртын дуу нь нүүдэлчин ахуй, амьдралтай холбоотой.

ӨМӨЗО -ны алдарт уртын дуучин Загдсүрэн (扎格达苏荣) “Уртын дууг сайн дуулахыг хүсвэл эхлээд Нугалааг сайн дуулах хэрэгтэй. Нугалаа бол Монголын ард түмний олон мянган жилийн турш дуулж ирсэн аялгуу, тэр дундаа жирийн малчдын үеийн үед дуулж ирсэн аялгуу юм. .. аав ээж, ахмад настны нөлөөгөөр олон хүн дуулж чаддаг, энэ нь үеэс үед уламжлагдан ирсэн байдаг” (Загдсүрэн, baidu, 2019). Мөн Загдсүрэн “уртын дуу яагаад ийм урт юм бэ? Бэлчээрийн зам урт, өндөр уулстай, алс холын гол мөрөнтэй болохоор тэр. Тэгтэл хүүхдүүд ирэхэд үнэхээр сэтгэл хөдлөм. Уртын дуу нь ордонд биш, тэнгэр газар хоёрын хооронд урсдаг. Өлгий нь уул ус, газар шороо. Хамгийн гүн нь. Бэлчээр, гол мөрөн, өргөө, морьтой хүмүүс үүнийг илүү сайн ойлгож, түүнгүйгээр амьдарч чадахгүй” (Загдсүрэн, sohu, 2007) гэж хэлсэн байна.

Уртын дууг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр анх судалсан хүн бол Оросын эрдэмтэн А.Позднеев юм. Тэрээр 1880 онд “Монгол уртын дуу” бүтээлдээ буриад, халх, өөлд дуунуудыг багтаасан байдаг. Оросын эрдэмтэн А.Д.Руднеев монгол уртын дуунуудын ая эгшгийг судалсан бол Б.Я.Владимирцов Ойрад дууг нарийн судалж тэмдэглэсэн байна (Алимаа, 2013). П.Хорлоо, Х.Сампилдэндэв, Ш.Дорж, Ж.Бадраа, С.Цоодол нарын зэрэг Монгол эрдэмтэн, судлаачид уртын дууны талаар судалсан бөгөөд Монгол нутгаар нэлээд тархмал байсан бичмэл судар, номуудыг ШУА-ийн ХЗХ-ийн зарим ахмад эрдэмтэд цуглуулсан байдаг. Мөн алдарт уртын дуучин Ж.Дорждагва уртын дуу судлалын түүхэнд томоохон орон зай эзлэх судалгааг хийсэн. Хөгжим судлаач, Ж.Бадраа түүнтэй хүүрнэсэн яриаг “Их дуучны яриа” нэртэй ном болгон хэвлүүлсэн нь энэ салбарын эрдэмтэн, судлаачдын дунд үнэ цэнтэй бүтээл болдог. Монгол ардын уртын дууны талаар сүүлийн жилүүдэд судлаачид ихээхэн сонирхон судалж, эрдэм шинжилгээний өгүүлэл, магистр болон докторын судалгааны ажил хийгдэж байна.

Дээрх судлаачдын бүтээлүүдээс үзэхэд уртын дуунд хандах хандлагыг судлагдсан бүтээлүүд хараахан хийгдээгүй байна. Иймээс бид даяарчлагдан өөрчлөгдөж буй мэдээллийн зуунд гаднын соёл хүчтэй дэлгэрч буй өнөө үед ирээдүй хойч үе болох оюутан залуусын уртын дуунд хандах хандлагыг судлах нь чухал хэмээн үзлээ.

Судалгааны арга зүй

Монгол ардын уртын дуунд хандах хандлага тодорхойлох хэмжүүрийн нэгэн хувилбар боловсруулахдаа Ажзены (1991) Төлөвлөсөн зан үйлийн онол, Нетглийн (1983, 2005) Хөгжмийн соёлын экологийн онолд үндэслэн боловсруулж, Лайкертийн 1-огт санал нийлэхгүй байна, 2- ерөнхийдөө санал нийлэхгүй, 3-зарим талаар санал нийлж байна, 4-ерөнхийдөө санал нийлж байна, 5-бүрэн санал нийлж байна гэсэн таван шатлалаар хэмжээжүүлсэн. Уг хэмжүүр нь гучин асуултаас бүрдэнэ.

Хэмжүүрийн уг хувилбараар МУБИС-ийн Багшийн сургуулийн бага ангийн багш болон хөгжмийн багийн I-IVкурсийн нийт 404 оюутнуудаас судалгаагаа авсан.

Судалгааны хэмжүүрийн найдвартай байдал (Кронбах-Альфа), Хуваарийн бүтцийн хүчинтэй байдлыг хайгуулын хүчин зүйлийн шинжилгээ, баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээгээр шалгасан. Монгол ардын уртын дуунд хандах хандлагыг суралцагчдын хүйс, нас, мэргэжил зэргээс хамаарч буй эсэхийг судлав.

Судалгааны үр дүн

Судалгаанд 17-24 насны 404 оюутны дунд судалгаа хамрагдсан 17-18 насныхан 16.1 хувь, 19-21 насныхан 73.5%, 22-24 насныхан 10.4 хувийг эзэлж байна. Түүнээс 9.9 % нь эрэгтэй, 364 буюу 90.1 % нь эмэгтэй суралцагчид байв.

МУБИС -ийн Багшийн сургуульд 1400 гаруй оюутан суралцаж байна. Үүнийг төлөөлж чадах түүврийн хэмжээг www.calculator.net ашиглан 95 хувийн итгэлтэй байх завсарт тооцоолж үзэхэд 306 гарсан нь 404 оюутан хамрагдсан нь хангалттай болохыг илтгэж байна. Бидний боловсруулсан оюутнуудын уртын дуунд хандах хандлагыг хэмжих хэмжүүрийн нэгэн хувилбарыг 30 асуултын найдвартай байдал

Хүснэгт 1 Судалгааны асуулгын найдвартай байдал

Кронбахын Альфа коэффициент	Тоо
.952	30

Кронбахын Альфа коэффициент нь 0.70 - аас их байвал хангалттай гэж үздэг (Hair et al, 2016, Лувсандорж.Ц 2021). Бидний боловсруулсан хэмжүүрийн Кронбахын Альфа нь 0.952 гарсан нь хувьсагчид болох асуултуудын дотоод нийцэл нь маш сайн байгааг илтгэж байна.

Хүснэгт 2. Кайзер-Мейер-Олкин ба Бартлетт тест (KMO and Bartlett's Test)


Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.948
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	8169.843
	df	435
	Sig.	.000

Бидний үр дүнгийн КМО-ийн утга 0.948 байна. Энэ нь хувьсагчдын мэдээллийн зэрэг нь маш их давхцаж байгааг/хүчтэй хэсэгчилсэн хамаарал байгааг харуулж

байна. Мөн Бартлетт тестийн $p(\text{sig.})=0.00$ байгаа нь фактор шинжилгээ хийх нь боломжтойг харуулж байна (Hair, J., Black, W., Babin, B., & Anderson, R., 2019).

Бид оюутнуудын уртын дуунд хандах хандлага хэмжих аргачлалын нэгэн хувилбарын хүчинтэй байдлыг үнэлж үзэх, цаашид хөгжүүлэх үүднээс фактор шинжилгээ хийлээ.

Зураг 1. Scree Plot



Scree Plot нь фактор ба хувийн утгуудын (Eigenvalue) хамаарлыг харуулдаг бөгөөд эндээс факторуудын ач холбогдол харагддаг (Denis, 2019). Нийт 30 бүлгийн хувийн утгыг ихээх нь бага руу харуулсан байна. Хувийн утга 1-ээс их байгаа нь 4 бүлэг фактор олборлогдсон байна.

Хүснэгт 3 Уртын дуунд хандах хандлагын факторын варимакс

	Ф1	Ф2	Ф3	Ф4
Асуултууд				
Хувийн утга	5.983	5.561	5.247	2.316
Варианс /Variance/ (%)	19.943	18.537	17.49	7.719
Хуримтлагдсан тархалт %	19.943	38.48	55.97	63.689

Факторын шинжилгээ хийж үзэхэд бидний 30 асуулт нь хувийн утга нь 1 -ээс дээш дөрвөн хүчин зүйлд хуваагдсан. Факторын ачаалал нь 0.4 дээш бол ач холбогдолтой, 0.5 -аас дээш бол маш их ач холбогдолтой хувьсагч юм. Хуримтлагдсан тархалтын нийлбэр нь **63.689** гарсан ба нийгэм, хүмүүнлэгийн ухаанд 60 хувиас дээш бол ач холбогдолтой гэж үздэг (Hair, J., Black, W., Babin, B., & Anderson, R., 2019). КМО - түүврийн нийцтэй байдал 0.948, $p=0.00$ нь 0.05 бага байгаа учир фактор шинжилгээ ач холбогдолтой байгааг илтгэж байна.

Фактор 1 (Ф1) – д “Монгол ардын уртын дуу бол Монгол үндэстний хөгжмийн өвийн салшгүй нэг хэсэг гэж би боддог”, “ Би Монгол ардын уртын дуугаар бахардаг”, “Монгол ардын уртын дууны тухай мэдэх нь өв соёлын боловсролд чухал гэж

боддог”, “Монгол ардын уртын дууг хүүхэд, залууст түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй гэж би үздэг”, “Уртын дууг сонсохоор монгол өв соёлтой холбоотой мэдрэмж надад төрдөг”, “Монгол ардын уртын дууны аялгуунууд надад сайхан санагддаг”, “Монгол ардын уртын дууг сонсохоор нэг л тайвшрах мэдрэмж төрдөг”, “Би монгол ардын уртын дуу дуулахад ямар төрлийн хөгжмийн зэмсгүүд хэрэглэдгийг мэднэ”, “Үе тэнгийнхнийхээ дунд уртын дууны нэр хүнд буурч байгаад би санаа зовж байна” гэсэн асуултууд факторлогдсон байна.

Фактор 2 (Ф2) – т “Монгол ардын уртын дууны түүх, уламжлалын талаар илүү ихийг мэдэхийг хүсэж байна”, “Орчин үед монгол ардын уртын дуу нь мартагдаж болзошгүй байгаад санаа зовж байна”, “Монгол ардын уртын дуутай холбоотой үйл ажиллагаанд оролцох сонирхолтой байна”, “Монгол ардын уртын дууг хойч үедээ өвлүүлж үлдээх нь чухал гэдгийг би ойлгож байна”, “Монгол ардын уртын дууг хадгалах, өвлүүлэхэд орчин үеийн технологи ашиглах хэрэгтэй”, “Монгол ардын уртын дуу нь монголын өв соёлын онцлогийг илэрхийлэхэд ямар чухал үүрэгтэйг ойлгодог”, “Би монгол ардын уртын дууг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулж чадна”, “Болж өгвөл монгол ардын уртын дууны тоглолт үзэх бодолтой байгаа”, “Би монгол ардын уртын дуу дуулж сурах бодолтой байгаа” гэсэн асуултууд факторлогдсон байна.

Фактор 3 (Ф3) – д “Би чөлөөт цагаараа монгол ардын уртын дуу сонсдог”, “Манай багш нар монгол уртын дууг ойлгож, үнэлэхийг уриалдаг”, “Би монгол ардын уртын дууны амьд тоглолтыг үзэж байсан”, “Монгол үндэстний нөлөө бүхий хүмүүс уртын дууны үнэ цэний талаар байнга ярьдаг”, “Найзууд маань монгол уртын дуунд эерэг ханддаг”, “Би олон нийтийн сүлжээгээр монгол уртын дуугаа дуулдаг уран бүтээлч эсвэл хамтлагуудыг дагадаг”, “Би Монгол ардын уртын дууг сонсох дуртай”, “Манай гэр бүлийнхэн уртын дууны уламжлалыг хадгалах нь чухал гэж үздэг”, “Би монгол ардын уртын дууны үг, утгыг ойлгодог” гэсэн асуултууд факторлогдсон байна.

Фактор 4 (Ф4)-д “Монголын уртын дууны зарим өв тээгчид, дуучдын нэрийг би мэднэ”, “Би монгол ардын уртын дууг сонсоод их баясдаг” гэсэн асуултууд факторлогдсон байна.

Бид бага ангийн багш болон хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй I-IV курсийн оюутнуудын хувьд уртын дуунд хандах хандлага тодорхойлох хэмжүүрийн асуулт бүр дундаж үзүүлэлт хоёр мэргэжлийн хувьд хэр зөрөөтэй буйг шинжилж үзэв. Шинжилгээний үр дүнг хүснэгт 4-д үзүүлсэн.

Хүснэгт 4. Статистик

Асуулт	мэргэжил	N	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа
Би монгол ардын уртын дууг сонсоод их баясдаг.	Бага ангийн багш	268	3.36	1.084	0.066
	Хөгжмийн багш	136	3.66	1.194	0.102
Монголын уртын дууны зарим өв тээгчид, дуучдын нэрийг би мэднэ.	Бага ангийн багш	268	3.12	0.941	0.057
	Хөгжмийн багш	136	3.20	1.160	0.099

Монгол ардын уртын дууны тухай мэдэх нь өв соёлын боловсролд чухал гэж боддог.	Бага ангийн багш	268	3.92	1.017	0.062
	Хөгжмийн багш	136	4.04	1.050	0.090
Би монгол ардын уртын дуу дуулахад ямар төрлийн хөгжмийн зэмсгүүд хэрэглэдгийг мэднэ.	Бага ангийн багш	268	3.51	1.033	0.063
	Хөгжмийн багш	136	4.01	1.036	0.089
Монгол ардын уртын дуу бол Монгол үндэстний хөгжмийн өвийн салшгүй нэг хэсэг гэж би боддог.	Бага ангийн багш	268	4.09	1.065	0.065
	Хөгжмийн багш	136	4.39	0.944	0.081
Би Монгол ардын уртын дууг сонсох дуртай.	Бага ангийн багш	268	3.31	1.037	0.063
	Хөгжмийн багш	136	3.73	1.119	0.096
Уртын дууг сонсохоор монгол өв соёлтой холбоотой мэдрэмж надад төрдөг.	Бага ангийн багш	268	3.79	1.063	0.065
	Хөгжмийн багш	136	3.94	1.059	0.091
Би Монгол ардын уртын дуугаар бахардаг.	Бага ангийн багш	268	4.11	1.035	0.063
	Хөгжмийн багш	136	4.35	0.857	0.073
Монгол ардын уртын дууны аялгуунууд надад сайхан санагддаг.	Бага ангийн багш	268	3.82	1.040	0.064
	Хөгжмийн багш	136	3.98	1.000	0.086
Монгол ардын уртын дууг сонсохоор нэг л тайвшрах мэдрэмж төрдөг.	Бага ангийн багш	268	3.62	1.051	0.064
	Хөгжмийн багш	136	3.92	0.997	0.085
Манай гэр бүлийнхэн уртын дууны уламжлалыг хадгалах нь чухал гэж үздэг.	Бага ангийн багш	268	3.59	1.096	0.067
	Хөгжмийн багш	136	3.57	1.184	0.102
Найзууд маань монгол уртын дуунд эерэг ханддаг.	Бага ангийн багш	268	3.15	1.049	0.064
	Хөгжмийн багш	136	3.36	1.107	0.095
Монгол үндэстний нөлөө бүхий хүмүүс уртын дууны үнэ цэнийн талаар байнга ярьдаг.	Бага ангийн багш	268	3.31	1.111	0.068
	Хөгжмийн багш	136	3.46	1.102	0.094
Монгол ардын уртын дууг хүүхэд, залууст түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй гэж би үздэг.	Бага ангийн багш	268	3.94	1.062	0.065
	Хөгжмийн багш	136	4.07	0.912	0.078
Манай багш нар монгол уртын дууг ойлгож, үнэлэхийг уриалдаг.	Бага ангийн багш	268	3.19	1.161	0.071
	Хөгжмийн багш	136	3.49	1.161	0.100
Би монгол ардын уртын дууны амьд тоглолтыг үзэж байсан	Бага ангийн багш	268	2.74	1.367	0.084
	Хөгжмийн багш	136	2.99	1.427	0.122
Би чөлөөт цагаараа монгол ардын уртын дуу сонсдог.	Бага ангийн багш	268	2.67	1.210	0.074
	Хөгжмийн багш	136	2.81	1.196	0.103

Би олон нийтийн сүлжээгээр монгол уртын дуугаа дуулдаг уран бүтээлч эсвэл хамтлагуудыг дагадаг.	Бага ангийн багш	268	2.87	1.254	0.077
	Хөгжмийн багш	136	2.97	1.333	0.114
Үе тэнгийнхнийхээ дунд уртын дууны нэр хүнд буурч байгаад би санаа зовж байна.	Бага ангийн багш	268	3.49	1.253	0.077
	Хөгжмийн багш	136	3.67	1.149	0.098
Би монгол уртын дууны үг, утгыг ойлгодог.	Бага ангийн багш	268	3.46	1.116	0.068
	Хөгжмийн багш	136	3.57	1.038	0.089
Болж өгвөл монгол ардын уртын дууны тоглолт үзэх бодолтой байгаа.	Бага ангийн багш	268	3.13	1.197	0.073
	Хөгжмийн багш	136	3.53	1.205	0.103
Монголын ардын уртын дууны түүх, уламжлалын талаар илүү ихийг мэдэхийг хүсэж байна.	Бага ангийн багш	268	3.63	1.171	0.072
	Хөгжмийн багш	136	3.92	0.974	0.084
Монгол ардын уртын дуутай холбоотой үйл ажиллагаанд оролцох сонирхолтой байна.	Бага ангийн багш	268	3.32	1.155	0.071
	Хөгжмийн багш	136	3.66	1.181	0.101
Би монгол ардын уртын дуу дуулж сурах бодолтой байгаа.	Бага ангийн багш	268	3.07	1.303	0.080
	Хөгжмийн багш	136	3.72	1.221	0.105
Би монгол ардын уртын дууг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулж чадна.	Бага ангийн багш	268	3.29	1.183	0.072
	Хөгжмийн багш	136	3.44	1.153	0.099
Монгол ардын уртын дуу нь монголын өв соёлын онцлогийг илэрхийлэхэд ямар чухал үүрэгтэйг ойлгодог.	Бага ангийн багш	268	3.65	1.133	0.069
	Хөгжмийн багш	136	3.68	1.093	0.094
Би монгол ардын уртын дууны бүс нутгийн янз бүрийн хэв маяг, хувилбаруудыг мэддэг.	Бага ангийн багш	268	3.03	1.183	0.072
	Хөгжмийн багш	136	3.08	1.180	0.101
Монгол ардын уртын дууг хойч үедээ өвлүүлж үлдээх нь чухал гэдгийг би ойлгож байна.	Бага ангийн багш	268	3.72	1.144	0.070
	Хөгжмийн багш	136	4.09	0.977	0.084
Монгол ардын уртын дууг хадгалах, өвлүүлэхэд орчин үеийн технологи ашиглах хэрэгтэй.	Бага ангийн багш	268	3.76	1.185	0.072
	Хөгжмийн багш	136	3.60	1.111	0.095
Орчин үед монгол ардын уртын дуу нь мартагдаж болзошгүй байгаад санаа зовж байна.	Бага ангийн багш	268	3.80	1.179	0.072
	Хөгжмийн багш	136	4.10	1.067	0.092

Дээрх хүснэгтээс үзэхэд хөгжмийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дундаж үнэлгээ бүх асуултад бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас өндөр байна. Энэ нь тэдний мэргэжлийн онцлогоос шалтгаалан уртын дууны талаарх мэдлэг, сонирхол, үнэлгээ илүү байгааг харуулж байна. Бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас ч мөн уртын дууг өв соёлын чухал хэсэг гэж үзэж байгаа боловч сонирхол, идэвх оролцооны хувьд хөгжмийн багшийн ангийн оюутнуудаас доогуур түвшинд байна. “Би монгол ардын уртын дууг сонсоод их баясдаг” асуултад бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд ($M=3.36$),

хөгжмийн багшийн ангийн оюутнууд ($M=3.66$) байна. “Би Монгол ардын уртын дууг сонсох дуртай” дээр хөгжмийн багшийн ангийн оюутнуудынх ($M=3.73$) бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас ($M=3.31$) илүү. Энэ нь хөгжмийн багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд уртын дууг сэтгэл хөдлөлөөр илүү хүчтэй хүлээж авч байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Хөгжмийн багшаар бэлтгэгдэж буй оюутнуудын дундаж үр дүн нь бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас илүү өндөр байна. Харин “Монгол ардын уртын дууг хадгалах, өвлүүлэхэд орчин үеийн технологи ашиглах хэрэгтэй.” гэсэн асуултад бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд 3.76, хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дундаж 3.60 байна. Энэ нь суралцаж буй мэргэжилтэй нь холбоотой нь харагдаж байна (Хүснэгт 4).

“Үе тэнгийнхнийхээ дунд уртын дууны нэр хүнд буурч байгаад би санаа зовж байна” гэсэн гэсэн урвуу асуултад судалгаанд хамрагдсан оюутнуудын 43% нь бүрэн санал нийлж байна, 21% нь санал нийлж байна, 23% нь зарим талаар санал нийлж байна хэмээн тус тус хариулсан нь нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 87% болж байна. Энэ нь соёлын биет бус өв монгол түмний бахархал болсон уртын дууны цаашид мартагдаж болзошгүй байгаад санаа зовж, эерэг хандлагатай байгааг илэрхийлж байгаа нь монгол түмний бахархал болсон уртын дуу, соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн судалгааны ажлыг өргөн хүрээнд хийх шаардлагатай болох нь харагдаж байна.

Ном зүй

1. (2004, 9 1). Retrieved from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/787>
2. (2008). Retrieved from unesco.org: <https://ich.unesco.org/en/RL/urtiin-duu-traditional-folk-long-song-00115#>
3. (2023, 11 3). Retrieved from mongoltoli.mn: <https://mongoltoli.mn/dictionary/detail/35980>
4. Ajzen, I. (1991). The theory of planned behavior. *Organizational Behavior and Human Decision Processes* (Vol. 50). Cited in Hansen.
5. Denis, D. J. (2019). *SPSS Data Analysis for Univariate, Bivariate and Multivariate Statistics*. John Wiley & Sons.
6. folkcloud. (2023). Retrieved from folkcloud.com: <https://folkcloud.com/folk-music-by-country/mongolia>
7. Hair, J., Black, W., Babin, B., & Anderson, R. (2019). *Multivariate Data Analysis*. Cengage Learning.
8. Nettl, B. (1983, 2005). *The study of ethnomusicology: Thirty-one issues and concepts*. University of Illinois Press. (2nd ed.). Urbana and Chicago: University of Illinois Press.
9. Алимаа, А. (2013). Монгол уртын дууны төрөл зүйл, тархалт, хувилбарын онцлог. Улаанбаатар: УБ Экспресс.
10. БНМАУ-ын угсаатны зүй (Vol. 1). (1987). Улаанбаатар: УБ УХГ.
11. Загдсүрэн. (2007, 11 1). sohu. Retrieved from [www.sohu.com: https://www.sohu.com/a/197884292_737785?fbclid](http://www.sohu.com/a/197884292_737785?fbclid)
12. Загдсүрэн. (2019, 11 3). baidu. Retrieved from [baijiahao.baidu.com: https://baijiahao.baidu.com/s?id](https://baijiahao.baidu.com/s?id)
13. Ширмэнтуяа, Д. (2020.10.22). Retrieved from <https://www.youtube.com/watch?v=pp6NtCDI6Bg>

DEVELOPMENT AND VALIDATION OF A SCALE FOR ATTITUDES TOWARD THE MONGOLIAN LONG SONG

^a Batkhuyag S., ^b Otgonbayar Ch., ^c WENYA
^aPhD., Teachers School, MNUE;
^bPhD., Teachers School, MNUE;
^cChina, Inner Mongolia

Corresponding author: otgonbayar.ch@msue.edu.mn 

Abstract

The purpose of this study was to develop and validate a scale for assessing the attitudes of pre-service primary school teachers and music teachers toward Urtiin Duu (Mongolian long song), an important element of the intangible cultural heritage of the Mongolian people. A total of 404 undergraduate students (first to fourth year) enrolled in primary education and music education programs at the School of Education, Mongolian National University of Education, participated in the survey.

Results from the exploratory factor analysis demonstrated strong construct validity, with a cumulative variance of 63.689%, a KMO value of 0.948, and statistical significance at $p < .05$. The internal consistency of the scale was confirmed with a Cronbach's alpha coefficient of 0.952, indicating high reliability. Four distinct factors were identified: Factor 1 – perceiving Urtiin Duu as a cultural treasure, a source of pride, and positive emotions; Factor 2 – active involvement in the preservation and dissemination of Urtiin Duu; Factor 3 – the role of the social environment (family, peers, teachers, and media) and daily practices; and Factor 4 – individual knowledge level and listening preferences. The validated scale provides a reliable tool for measuring attitudes toward Urtiin Duu and offers valuable insights for the preservation, promotion, and intergenerational transmission of Mongolia's intangible cultural heritage, as well as for the development of music education.

Keywords

Long Song, intangible cultural heritage, attitude scale, validity, reliability, music education
